

## МОСКВАГИЙН ТУНХАГЛАЛ

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путиний урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2006 оны 12-р сарын 4-9-нд ОХУ-д айлчлал хийв.

Илэн далангүй, итгэлцсэн байдалд болсон хэлэлцээний явцад хоёр улсын төрийн тэргүүн нар 2000 оны 11-р сарын 14-ний өдөр Улаанбаатар хотын тунхаглалыг байгуулснаас хойших үеийн хоёр талын харилцааны хөгжлийг дүгнээд Монгол, Оросын харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, олон улсын болон бүс нутгийн харилцан сонирхсон тулгамдсан асуудлаар санал солилцов.

1. Монгол Улс болон ОХУ хоёр орны ард түмний хооронд түүхийн явцад бий болсон уламжлалт найрсаг харилцаа, харилцан итгэлцлийг тууштай сахин баримтлаж байгаагаа нотлон, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны 1-р сарын 20-ны өдрийн Монгол Улс, ОХУ-ын хоорондын Гэрээг удирдлага болгон цаашид хоёр орны олон талын хэлхээ холбоог улам өндөр, чанарын шинэ түвшинд гаргах зорилготой стратегийн түншлэлийн харилцааны үзэл санааны дагуу хоёр талын хамтын ажиллагааны цар хүрээг тууштай өргөжүүлэн зузаатгаж, агуулгын хувьд баяжуулан, үр ашгийг нь дээшлүүлэх болно. Монгол, Оросын хамтын ажиллагаа нь бүх хүрээнд адил тэгш тусгаар тогтнох, харилцан ашигтай байх, нутаг дэвсгэрээ бүрэн бүтэн байлгах, дотоод хэрэгт нь үл оролцох зарчим болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчим, хэм хэмжээний үндсэн дээр хөгжих ёстой гэдэгт санал нэгтэй байна.

2. Талууд сүүлийн жилүүдэд хэвшсэн улс хоорондын улс төрийн хэлхээ холбооны механизмаа бэхжүүлэхийг чухал ач холбогдолтой гэж үзэн хоёр талын харилцааны эрч хүч, зохистой чиг шугамыг хангаж байдаг Монгол, Оросын улс төрийн дээд болон өндөр хэмжээний улс төрийн тогтмол яриа хэлэлцээ нь онцгой үүрэгтэйг тэмдэглэн, тэдгээрийг шинэ агуулгаар баяжуулан, хоёр орны гүйцэтгэх засаглалын болон хууль тогтоох дээд байгууллага хоорондын гадаад бодлогын болон бусад зөвлөлдөх уулзалт хийх туршлагыг хөгжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

Талууд 2003 онд Монгол Улсын шилжих рублийн өрийг зохицуулсан нь хоёр орны бүх талын хамтын ажиллагааг зузаатгах шинэ боломж нээж өгснийг сэтгэл ханамжтай тэмдэглэв.

Талууд харилцаагаа янз бүрийн салбарт хөгжүүлэхэд бэлэн байгаагаа батлан, энэ зорилгоор Монгол Улс, ОХУ-ын хоорондын

харилцааны гэрээ, эрх зүйн үндсийг боловсронгуй болгохын чухлыг тэмдэглэв. Үүнтэй холбогдуулан айлчлалын явцад дараах баримт бичгүүдэд гарын үсэг зурсанд сэтгэл ханамжтай байгаагаа тэмдэглэв.

- Монгол, Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ;

- Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөр;

- Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаварыг арилгах асуудал эрхэлсэн яам хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх протокол;

- Төмөр замын тээврийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Зам тээвэр аялал жуучлалын яам, Орос Холбооны Улсын Тээврийн яам хоорондын харилцан ойлголцлын тухай санамж бичиг;

- Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, хоорондын 2007–2008 оны хамтын ажиллагааны хөтөлбөр;

- Монгол Улсын Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Оросын Холбооны Улсын Цагаачлалын албаны хооронд цагаачлалын хүрээнд харилцан ойлголцлын болон хамтын ажиллагааны тухай санамж бичиг;

- Монгол Улсын Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Холбооны Соёл, кино урлагийн агентлаг /Оросын холбооны Улс/ хоорондын 2006–2008 оны хамтын ажиллагааны хөтөлбөр;

- Монгол Улсын цахилгаан мэдээллийн агентлаг МОНЦАМЭ, Оросын Холбооны Улсын нэгдмэл үйлдвэрийн газар болох “Оросын цахилгаан мэдээллийн агентлаг (ИТАР - ТАСС)” хоорондын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр;

3. Хоёр талын худалдаа эдийн засгийн харилцааг хөгжүүлэх асуудлаар Талууд нухацтай, үр бүтээлтэй санал солилцов. Хоёр орны эдийн засаг харилцан нөхдөг бөгөөд худалдаа, эдийн засгийг цаашид хөгжүүлэх өргөн боломж байгааг Талууд тэмдэглэн, харилцан хөгжихөд чармайлт гаргах хатуу эрмэлзлэлтэй байгааг илэрхийлэв.

Олон улсын орчин үеийн стандарт, эдийн засгийн бодит байдлын дагуу эдийн засгийн төрөл бүрийн салбар, ялангуяа түлш эрчим хүч, геологи, уул уурхай үйлдвэрлэл, тээврийн болон хөдөө аж ахуйн салбарт түүнчлэн санхүү банкны бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд өргөнөөр оролцохыг эрмэлзэх шаардлагатайг Талууд хүлээн зөвшөөрөв.

Хоёр талын худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, харилцан хөрөнгө оруулах, таатай нөхцөл бүрдүүлж, түүнийг хоёр орны үндсэн хууль тогтоомжийн хүрээнд хамгаалах баталгаатайгаар хангахад хамтарсан

хүчин чармайлт гаргах хэрэгтэй гэдэгт Талууд нэгдэв.

Талууд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын ажлыг эерэгээр дүгнэн бараа эргэлтийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх, худалдааны бүтцийг өөрчлөн сайжруулах, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор тус комиссын үйл ажиллагааны үр ашгийг цаашид дээшлүүлэх сонирхолтой байна.

Талууд хоёр улсын хамтын ажиллагаа, Монголын эдийн засагт үлэмж хувь нэмэр оруулж буй “Эрдэнэт”, “Монгол росцветмет” хамтарсан үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох хэтийн төлөвтэй хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх бодлогыг хамтран боловсруулах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.

Хоёр орны хоорондын хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд хамтарсан хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг чухал ач холбогдолтойг тэмдэглэн УБТЗ-ыг шинэчлэх, удирдлагын бүтцийг зохистой болгох, түүний үйл ажиллагааны гэрээ эрх зүйн суурийг шинэчлэх, түүнчлэн үнэ тарифын зохицуулалтын арга хэмжээг оролцуулан Орос улс, Хятад улсын хооронд Улаанбаатар төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн тогтвортой өсөлтийг хангах асуудлыг боловсруулах шаардлагатайг Талууд хүлээн зөвшөөрөв.

Талууд хоёр орны бүс нутгийн харилцаа холбоо, хил орчмын хамтын ажиллагаа, худалдааг хөгжүүлэх, хоёр улсын иргэд харилцан зорчих дэг журмыг хөнгөвчлөх, дэлхийн эдийн засаг дахь интеграцийн үйл явцын үр дүнд нээгдэж байгаа шинэ боломжыг харилцан ашигтайгаар ашиглахын төлөө байгаагаа илэрхийлэв.

Талууд үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх үр дагаврыг арилгах талаар, түүний дотор Монгол Улс, Орос Улсын хилийн орчмын бүсэд хамтын ажиллагаагаа үргэжлүүлэхээр тохиролцов. Оросын тал Монгол Улсад үндэсний аврах албаны боловсон хүчнийг сургах, тусгай техник, багаж төхөөрөмжөөр хангахад харилцан ашигтай байх үндсэн дээр тус дөхөм үзүүлж байх болно.

Монгол Улс, Орос Улс экологийн аюулгүй байдлыг харилцан хангах, хоёр орны нутаг дэвсгэрийг хамарсан бохирдлоос хамтран урьдчилан сэргийлэхийн тулд хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх болно.

4. Хоёр орны ард түмний оюун санааны болон соёлын ойр дотно уламжлалт хэлхээ холбоог хадгалан бэхжүүлэхийн төлөө байдаг. Монгол Улс, ОХУ-ын Улсын их дээд сургуульд суралцаж буй Монгол

оюутны тоог нэмэгдүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, давтан бэлдэх, сургалт хөтөлбөр боловсруулах замаар хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах болно. Талууд хүмүүс болон олон нийтийн байгууллага хоорондын хэлхээ холбоог, түүний дотор соёл, боловсрол, мэдээллийн хэрэгсэл, залуучуудын солилцоо болон спортын салбарт идэвхтэй тус дөхөм үзүүлэх Монгол Улсад орос хэлийг, Орос улсад монгол хэлийг сургах, судлахыг хөхиүлэн дэмжих болно.

Хоёр талын бүс нутгуудын онцлогийг харгалзан, юуны өмнө Хөвсгөл, Байгаль нууруудын сав газар нутагт аялал жуулчлалын маршрут зохион байгуулахын тулд зохих дээд бүтцийг бий болгоход чиглэсэн аялал жуулчлалын цогц хөтөлбөр хамтран боловсруулахаар Монгол Улс, ОХУ тохиролцов.

Хөдөлмөрийн цагаачлалын хүрээг оролцуулан хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааны асуудлыг зохицуулж буй гэрээ, эрх зүйн суурийг боловсронгуй болгох ажлыг Талууд үргэлжлүүлнэ.

5. Монгол Улс, Оросын Холбооны Улс цэргийн болон цэрэг, техникийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн боловсронгуй болгож, мэдээлэл солилцох, шинэ аюул, заналхийллийн эсрэг тэнцэх салбарыг оролцуулан хуулийн болон хууль сахиулах байгууллага, тусгай албад, түүнчлэн хил хамгаалах байгууллагын хооронд шууд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

Талууд хоёр улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлүүдийн Хамтын ажиллагааны тухай 1995 оны 5-р сарын 26-ны өдрийн протоколын үндсэн дээр Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Оросын Холбооны Улсын Аюулгүй Байдлын Зөвлөлийн хооронд үндэсний болон олон улсын аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэн зохицуулж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв.

6. Талууд дэлхийн байдлыг хэлэлцэхдээ бүс нутгийн болон олон улсын гол асуудлаар ойр ба ижил төстэй байр суурьтай байгаагаа илэрхийлэв.

Даяаршлалын эрч хүчээ авч буй үйл явц улс орнуудын харилцан хамаарлыг нэмэгдүүлж, улмаар аюулгүй байдал, хөгжин цэцэглэлт салшгүй холбоотой болж байгааг Монгол Улс, Орос Улс тэмдэглэв. Аюулгүй байдалд аюул занал учруулж буй олон улсын терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхины наймаа зэрэг нь дэлхийн нийтийн шинжтэй болж байна. Тэдгээрийн эсрэг зөвхөн хүчин чармайлтаа нэгтгэн хамтын ажиллагааны тохиролцсон зарчим, механизмыг баримтлан байж үр ашигтай тэнцэж болно.

Монгол Улс, Орос Улс нь улс орнууд өөрийн түүхэн туршлагын

дагуу хөгжлийн замаа бие даан сонгох, олон улсын үйл ажиллагаанд эрх тэгш оролцох эрхтэйг хүлээн зөвшөөрч, орчин үеийн дэлхийн соёл иргэншлийн олон хэлбэрийг хүндэтгэх шаардлагатайг онцгойлон тэмдэглэв.

Монгол Улс, Орос Улс бүх түвшинд тогтвортой, аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн таатай нөхцлийг бүрдүүлэх, шинэ илүү шудрага, ардчилсан дэлхийн дэг журмыг тогтоох зорилгоор хоёр талын хэмжээнд төдийгүй сонирхсон бүх түнштэйгээ илүү өргөн хамтран ажиллахад бэлэн байгаагаа нотлов. Дэлхий дахины ийм тогтолцоо нь олон улсын үйл ажиллагаанд хууль ёсны онцгой эрх бүхий НҮБ, түүний Аюулгүй Зөвлөлийн голлон зохицуулах үүрэг болон олон улсын эрх зүйг дээдлэх зарчмыг хүлээн зөвшөөрсөн хамтын хүчин чармайлтыг үндэслэх ёстой.

Олон улсын болон бүсийн мөргөлдөөн хямралыг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн бүх оролцогч талын хууль ёсны эрх ашгийг харгалзах үндсэн дээр улс төр – дипломат аргаар зохицуулах ёстой гэж Монгол Улс, Орос Улс үзэж байна.

Талууд шинэ сорилт, аюул занал, юуны өмнө терроризмын бүх хэлбэр, илрэл, хар тамхины хууль бус эргэлт, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг тэмцэх талаар НҮБ-ын хүрээнд болон бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх болно.

Орос Улс нь Монгол Улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан түүний аюулгүй байдалд баталгаа олгох тухай цөмийн зэвсэгтэй таван гүрний Хамтарсан мэдэгдэлд үнэнч байгаагаа дахин нотолж, энэхүү статус нь Зүүн Хойд Азид болон түүний гадна итгэлцлийг бэхжүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ мөн бөгөөд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэгийг бэхжүүлэхэд тус дөхөмтэй гэж үзэж байна.

Монгол Улс, Орос Улс Зүүн Хойд Ази болон Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, тогтвортой, аюулгүй байдлыг хангах, хамтын ажиллагааг өргөтгөх асуудлаар тогтмол зөвлөлдөж, хүч чармайлтаа уялдуулж байх шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Талууд АСЕАН-ы бүсийн чуулга, Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ, Азид хамтран ажиллах, итгэлцлийн арга хэмжээний асуудлаарх зөвлөлдөөн зэрэг улс төр, эдийн засгийн интеграцчиллын олон талын механизмыг бэхжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлээд, энх тайван, аюулгүй байдал, хамтын хөгжил цэцэглэлтийн эрх ашгийн үүднээс улс хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэхийг уриалав. Орос Улс “Ази, Номхон далайн Эдийн засгийн хамтын ажиллагаа” чуулгад

гишүүнээр элсэх Монгол Улсын эрмэлзлэлийг дэмжиж байгаагаа нотлож байна.

Монгол Улс, Орос Улс Төв Азийн улс орнуудын сайн хөршийн харилцаа, олон талт түншлэлийг хөгжүүлэхэд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв. Талууд “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын таван жилийн ойн тунхаглал”-ын үзэл санааны дагуу эрчим хүч, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, хөдөө аж ахуй зэрэг тэргүүлэх салбарт ШХАБ-ын хүрээнд түншлэлээ идэвхжүүлэхийг сонирхож байгаагаа илэрхийлэв.

Монголын тал Евроазийн эдийн засгийн хамтын нийгэмлэгт Монгол Улс элсэх асуудлыг судалж байгаагаа Оросын талд мэдээлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Москва хотод халуун дотноор хүлээн авсанд нь талархал илэхрийлж, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путиныг тааламжтай үедээ Улаанбаатарт айлчлахыг урив. Урилгыг талархан хүлээн авав.

*Москва хот 2006 оны арванхоёрдугаар сарын 8*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.В.ПУТИН